Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн
61 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль |
| Дагаж мөрдөх огноо: | 2022 оны 01 дүгээр сарын 01 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Гаалийн ерөнхий газар | Хяналт, бүрдүүлэлтийн газар |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
| Хяналт, бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч | Дэс түшмэл ТТ-5 |
| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | 14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу 81-1 |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой олон улсын гэрээ, конвенц, гаалийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гаалийн хяналттай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлж, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гаалийн хяналтын тоног төхөөрөмж, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах санал боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах;
2. Бүрдүүлэлтийн горим, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлж, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
3. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.

| Зорилт | | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх - Г, Хянах - Х, Шийдвэрлэх - Ш |
|---|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. | Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах, танилцуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах; | Гаалийн тухай хууль бусад холбогдох хууль, эрхийн актад нийцсэн байна. | Г, Х |
| | 2. | Гаалийн баталгаат болон тусгай бүс, гаалийн хяналтын бүс, гаалийн түр агуулахын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох санал боловсруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах; | Зохион байгуулсан ажлын тоо, шийдвэрлүүлсэн саналын тоо | Х, Г, |
| | 3. | Гаалийн зам тогтоох, тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох, хүчингүй болгох санал боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; | Хэрэгжилт хангагдсан байна. | |
| | 4. | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын гаалийн хилээр нэвтрүүлсэн бараанд хяналт тавих ажлыг зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Г |
| | 5. | Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа, оюуны өмчийн эрхтэй холбоотой бараанд тавих гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Боловсруулсан санал, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | Г, Х |
| | 6. | Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар гаалийн байгууллагын байр суурийг | Бодлогын баримт бичиг, бусад төсөл, хөтөлбөрт санал өгсөн байдал, үр | Т, Г |

МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| | гадаад, дотоодод төлөөлөх, гаалийн харилцаанд оролцогч нарт мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; | дүн | |
| | 7. Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийг сайжруулахад хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр санал боловсруулж, хэрэгжүүлэх; | Гаалийн программ хангамжийн сайжруулалт, үр дүн | Г, Х |
| | 8. Ашигт малтмалын экспортын бүрдүүлэлтэд судалгаа хийж, экспортын бүрдүүлэлтэд зарцуулж буй цаг хугацааг багасгах санал боловсруулах; | Судалгааны тоо, программ боловсронгуй болсон байх | Г, Т |
| | 9. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, санал боловсруулах, гаалийн харилцаанд оролцогчидтой уулзаж, мэдээллийг урьдчилж авах боломжийг судлах; | Хамтран ажилласан байгууллагын тоо | Г |
| | 10. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт зааварчилгааг боловсронгуй болгох, гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулах; | Зааварчилгааг гаргасан байх, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | Г |
| | 11. Гаалийн хилээр нэвтэрсэн барааны нэр төрлөөр судалгаа, дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтын төлөвт дүн шинжилгээ хийх, хяналтыг сайжруулах санал боловсруулах; | Судалгаа, дүн шинжилгээ, саналын тоо, чанар | Т, Г |
| | 12. Гаалийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, зөрчлийн байдал, зөрчилд холбогдсон бараа, зөрчил үйлдсэн арга, зөрчил үйлдэгч, давтамжид судалгаа хийж, хяналт, шалгалтын тактик боловсруулах; | Дүн шинжилгээ, тактик, чиглэлийн тоо, чанар | Г |
| | 13. Хил залгаа орнууд болон бусад орны гаалийн байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагааг судлах, үндэсний онцлогт тохируулан нэвтрүүлэх дэвшилтэт аргыг судалж, санал боловсруулах.; | Судалгааны тоо, чанар | Г |
| | 14. Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтад судалгаа, дүн | Судалгаа, дүн шинжилгээ, саналын | Г |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | шинжилгээ хийх, хяналтыг сайжруулах санал боловсруулах; | тоо, чанар | |
| | 15. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хязгаарласан бараанд дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтыг боловсруулах санал боловсруулах; | Судалгаа, дүн шинжилгээ, саналын тоо, чанар | Г |
| | 16. Шуудан илгээмж, цахим худалдаанд тавих гаалийн хяналтыг олон улсын жишигт хүргэх талаар санал боловсруулах, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах; | Хамтран ажилласан байгууллагын тоо, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | Г |
| | 17. Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд тавих гаалийн хяналтыг сайжруулах чиглэлээр санал боловсруулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | Г |
| | 18. Дипломат төлөөлөгчийн газрын бараанд тавих гаалийн хяналтын чиглэлээр санал боловсруулах, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах; | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | Г |
| | 19. CPD карнейтай тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих; ТИР карнейгаар нэвтэрч байгаа бараанд хяналт тавих; | Конвенцын хэрэгжилт хангагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | Г |
| | 20. Олон улсын авто тээвэрчдийн нэгдсэн холбоотой хамтран ажиллаж, ТИР карнейн мэдээлэлд хяналт тавих, шаардлагатай мэдээлэл солилцох; | Мэдээ хугацаандаа илгээгдэж, хамтын ажиллагаа сайжирсан байна | Г |
| | 21. Хилийн боомтын нэвтрэх чадварыг дээшлүүлж, худалдааг хөнгөвчлөх зорилгоор бусад орны ухаалаг гарц хэрэгжүүлсэн туршлагаас судалж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа боловсруулах. | Судалгааны үр дүн | Г |
| | 1. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гаалийн газар, хороодыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, чиглэлээр хангах ажлыг зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Т |
| | 2. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хялбаршуулах, цаг хугацааг хэмжих, үр дүнг тооцох ажлыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г, Х |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| 2 дугаар зорилтын хүрээнд | 3. Барааны бичиглэлийг (унификаци) ижилсгэх ажлыг холбогдох нэгжтэй хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г, Х |
| | 4. Экспортын ашигт малтмалын гаалийн бүрдүүлэлтийн зарим үйл ажиллагааг цахимжуулах, бусад орны жишигт нийцүүлэн боловсронгуй болгох; | Ашигт малтмалд хийх гаалийн хяналт шалгалтыг хялбарчлах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | Г |
| | 5. Нүүрс болон бусад ашигт малтмал шалгах орчин үеийн техник тоног төхөөрөмжийг судлах, удирдлагад танилцуулах; | Орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг судалж, удирдлагыг мэдээллээр хангасан байх | Г |
| | 4. Экспортын ашигт малтмалын бүрдүүлэлтийн зарим үйл ажиллагааг цахимжуулсантай холбогдуулж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж, алдааг бууруулах; | Газар, хороодод гарч буй программын алдааг бууруулсан байна | Г |
| | 5. Оюуны өмчийн эрхэд хамаарах бараанд хяналт тавих ажлыг зохион байгуулах, гаалийн бүртгэлийг боловсронгуй болгох, цахимжуулах, гаалийн газар, хороодыг зөвлөмж, заавраар хангах; | Зөвлөмж, заавар хүргүүлж, бүртгэлийг цахимжуулсан байх | Г |
| | 6. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хялбарчлах талаар судалгаа хийж, санал боловсруулан, холбогдох газар хороо, нэгжүүдтэй хамтран ажиллах, шийдвэрлүүлэх; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Г |
| | 7. Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулагдаж буй цаг хугацааг тодорхойлохоор цуглуулсан мэдээллийг нэгтгэн хянаж, Дэлхийн гаалийн байгууллагын TRS-ийн программд шивж оруулан боловсруулалт хийх; | Мэдээллийг цуглуулж, Дэлхийн гаалийн байгууллагын санд оруулсан байх | Г |
| | 8. Итгэмжлэгдсэн аж, ахуйн нэгж хөтөлбөрийн хүрээнд зориулан худалдааг хөнгөвчлөх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Г |
| | 9. Программ хангамжуудын уялдаа холбоог сайжруулах, давхардсан үйлдлийг багасгах санал боловсруулах; | Саналын тоо, чанар | Г |
| | 10. Гаалийн хяналтад ашиглах орчин үеийн хяналтын тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, гаалийн газар, хороодыг үе шаттайгаар хангах санал боловсруулж хэрэгжүүлэх; | Газар хороодыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байдал | Г |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| | 11. Гаалийн газар, хороодод ашиглагдаж байгаа гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах; | Үр дүнг тооцсон байх | Г |
| | 12. "Авто тээврийн үндэсний төв" Төрийн өмчит үйлдвэрийн газрын VRS систем, Гаалийн байгууллагын автоматжуулсан системийн хооронд мэдээлэл дамжуулах тээврийн бүртгэлийн программыг хөгжүүлэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах; | Мэдээлэл солилцсон байх | Г |
| | 13. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих. | Хаалт хийгдээгүй тээврийн хэрэгслийн тоог бууруулсан байх | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахдаа эрсдэл тооцож, үр дүнг тайлагнах; | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн | Г |
| | 2. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбогдох асуудлаар хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г |
| | 3. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна | Т, Г |
| | 4. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулах; | Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна | Г |
| | 5. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамжийг боловсронгуй болгох санал өгөх; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г |
| | 6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх |
| Мэргэжил | - Худалдаа (0416),<br>- Менежмент ба удирдахуй (0413) |

МОНГОЛ УЛС ЗОВШООРОВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| | - эрх зүй (0421),<br>- бараа, түүхий эдийн судлал, технологи (072205),<br>- эдийн засаг (031101). | |
| Мэргэшил | Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;<br>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;<br>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, харьцуулсан судалгаа хийх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах;<br>- мэдээлэлд тулгуурлан хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон чиг үүргийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ, хийх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах. |
| | Асуудал шийдвэрлэх | - сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх;<br>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>- асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;<br>- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах. |
| | Бусад | - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- гадаад худалдаа, гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцан, өөрийгөө хөгжүүлэх;<br>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;<br>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, гаалийн харилцаанд оролцогчидтой харилцах. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хяналт бүрдүүлэлтийн газрын дарга, гаалийн улсын ахлах байцаагч

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох ажилтан;<br>- Гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд;<br>- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан. |
|---|---|
| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА<br>..........................................Ч.ТАМИРАА<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2023 оны 9 сарын 11 -ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 23 03 09<br>Дугаар: 061 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br>ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР<br>Шийдвэрийн огноо:....................................<br>Дугаар:...........<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА..................................................Р.ОТГОНЖАРГАЛ<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2023 оны 04 дугаар сарын 12 -ны өдөр | |